

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 ОНЫ 6 ДУГААР САР

1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын компаниудын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны 6 дугаар сарын байдлаар харуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

		/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	2009-III	2009-IV	2009-V	2009-VI
1	Даатгалын нийт хураамж	1,508,145,368.04	2,843,688,725.79	1,782,770,692.46	2,838,837,239.32
2	Олгосон нийт нөхөн төлбөр	403,969,016.33	417,448,114.06	439,751,675.38	411,527,290.01
3	Давхар даатгалд төлсөн хураамж	638,508,028.89	543,281,677.87	386,433,464.28	182,185,541.74
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	13,586	39,878	16,684	12,321
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	43,590,000,000.00	45,803,855,532.00	7,425,600,000.00	24,565,000,000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	35,335,580.00	50,000,000.00	46,776,886.00	21,245,607.00

2009 оны 6 дугаар сарын даатгалын хураамжийн орлого 5 дугаар сарынхаас 62.7 хувиар нэмэгдсэн хэдий ч олгосон нөхөн төлбөр 28.2 сая төгрөгөөр буурсан байна. Давхар даатгалд “Монгол даатгал”, “Ард даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Бодь даатгал”, “Прайм женерал даатгал” ХХК-иуд 182.1 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Даатгалын компаниудаас 6 дугаар сард хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК нь Худалдаа хөгжлийн банкинд зээлийн даатгалын гэрээний нөхөн төлбөрт олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

		/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	2009-III	2009-IV	2009-V	2009-VI
1	Даатгалын нийт хураамж	1,379,750.00	4,555,858.00	1,061,106.00	1,646,849.00
2	Олгосон нийт нөхөн төлбөр	600,000.00	0.00	0.00	296,000.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	0.00	0.00	0.00	0.00
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	5 гэрээ (68 хүн)	3 гэрээ (35 хүн)	6 гэрээ (22 хүн)	4 гэрээ (4 хүн)

5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	50,000,000.00	50,000,000.00	51,000,000.00	50,000,000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	375,000.00	0.00	0.00	200,000.00

6 дугаар сард “Нэйшнл лайф даатгал” ХХК 4 хувь хүнтэй “Хувь хүний хугацаат амьдралын даатгал”-ын гэрээ байгуулсан байна. Хөдөлмөрийн чадвар түр алдалтын нэмэлт нөхцөлөөр 296,000.0 төгрөгийн нөхөн олговор олгосон байна.